

БАТЛАВ:
СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГЫН
ДАРГА, ХУРАНДАА Б. ТАМИР

ШШГЕГ-ЫН ХАРЪЯА СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГА

**НҮҮРС НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: НҮҮРС НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕР

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ШШГЕГСХТ/20200103

УЛААНБААТАР ХОТ

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020.09.28

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад нүүрс нийлүүлэх** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50.000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn –ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.

Үнийн саналыг 2020 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 11-р хороо, Хонхор хотхон Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага-д 2020 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 11-р хороо, Хонхор хотхон Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, утас: 89092442, 98119088

Цахим хуудас: tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь, төсөв;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) ТШӨХ-т заасан бусад шаардлагатай мэдээлэл
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ
 - 4.2 Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3 Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шат ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захийлагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4 Тендерт оролцогчнь тендерийн хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу нэн гэрээ бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн бусад үнэд багтаасан байна.

5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна.
- а. Тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ.
- б. Үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна.
- в. Нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаар нэгж үнэд аравтын ороны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна
- 6.2 Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТӨӨЗ 1.1	Захиалагч нь: ШШГЕГ-ын Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага
ТӨӨЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар:
ТӨӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй
ТӨӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: улсын төсвийн хөрөнгө
	Б. Тендерийн баримт бичиг
ТӨӨЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 11-р хороо Хонхор хотхон Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага утас:89092442, 80100411
ТӨӨЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын [5] хоногоос багагүй байна.
	В. Тендер бэлтгэх
ТӨӨЗ 11.1	Тендерийн баримт бичиг Монгол хэл дээр байна.
ТӨӨЗ 12.1 (в)	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд: 1.Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг нотариатаар баталгаажуулан төлөөлөх эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхийг хуулбарын хамт ирүүлнэ.
ТӨӨЗ 12.1 (ё)	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: 1. Харьяа Татварын хэлтсийн тодорхойлт /цахим/ : Ирүүлэх шаардлагагүй бөгөөд www.tender.gov.mn цахим системээс хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг шалгана. 2. Харьяа Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт. 3. Харилцагч банкуудын тодорхойлолт. /Улсын бүртгэлийн гэрчилгээнд бичилттэй харилцагч банкууд багтана. Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна./ 4. Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны /төрөлжсөн архив/ тодорхойлолт. 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт.

	<p>Тендерт оролцогч нь харьяа Татвар, нийгмийн даатгал, харилцагч банкнуудаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлнэ. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно. <i>/Дээрх тодорхойлолтуудыг эх хувиар бэлтгэж цахим хэлбэр (pdf)-ээр ирүүлнэ/.</i></p> <p>6. Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн санал, тендерийн үр дүнг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>7. Тендерийн баримт бичгийн 5,6 дугаар бүлэгт заагдсан <i>Гэрээний ерөнхий болон Тусгай нөхцөл</i>, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>8. Компаний танилцуулга ирүүлнэ.</p> <p>9. Үйлдвэрлэгч, гэрээт борлуулагчийн итгэмжлэл ирүүлнэ.</p> <p>10. Нийлүүлэх нүүрсний техникийн тодорхойлолтын дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны төв лабораторийн тодорхойлсон шинжилгээний бичиг ирүүлнэ.</p> <p>11. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэд багтаан бараа нийлүүлэх нарийвчилсан хуваарын дагуу захиалагчийн заасан газарт өөрийн зардлаар нүүрс нийлүүлж өгөх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</p>
ТӨЭЗ 13.1	Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн нарийвчилсан хугацааны хуваарийг МАЯГТ №: ТШМ-2 ын тохирох маягтын дагуу компаний удирдлагаар баталгаажуулан ирүүлнэ.
ТӨЭЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.
ТӨЭЗ 15.9 (б) (1) and (в) (3)	Бараа хүргэгдэх газар: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 11-р хороо Хонхор хотхон Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага
ТӨЭЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)	Бараа хүргэгдэх эцсийн цэг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 11-р хороо Хонхор хотхон Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага
ТӨЭЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад "тохируулахгүй тогтмол байна "
ТӨЭЗ 16.1	Тендерийн валют: Төгрөг байна.
ТӨЭЗ 17.1 (а)	Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээ: Ирүүлэх шаардлагагүй бөгөөд www.tender.gov.mn цахим системээс хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг шалгана.
ТӨЭЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 1 жил буюу 2019 оны эцсийн санхүүгийн тайланг ирүүлнэ.
ТӨЭЗ 18.1 (в)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 1 жил /2019-ийн аль нэгэнд ядаж нэг удаа 44 000 000 /дөчин дөрвөн сая/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй бараа нийлүүлсэн ажилласан туршлагатай байна.

	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр холбоо барих утас/факс	Төсөвт өртө	Дууссан, эсхүл дуусах хугацаа
	1				
		дүн			
	Дээрх онуудад энэхүү гэрээгээр хийгдэх ажилтай ижил төстэй нотлох баримт ирүүлнэ.				
ТӨӨЗ 18.1 (г)	Голлох болон ИТА-ууд дараах шаардлагыг хангасан байна.				
	№	Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага	мэргэжил
	1	Жолооч	1	3 дээш	С ангилалтай
	2	Туслах жолооч	1	2 дээш	С ангилалтай
	Жолооч , туслах жолоочийн иргэний үнэмлэхний хуулбар , жолооний үнэмлэхний хуулбаруудыг наториатаар баталгаажуулж ирүүлнэ.				
ТӨӨЗ 18.1 (д)	Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: 1. Ачааны автомашин 20 тонн дээш / 3ш ба түүнээс дээш байна./ 2. Тээврийн хэрэгслийн техникийн гэрчилгээний хуулбарын наториатаар баталгаажуулж фото зургийн хамт ирүүлнэ. 3. Түрээсээр хэрэглэх бол тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар, түрээсийн гэрээ, фото зураг хавсарган ирүүлнэ				
ТӨӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: шаардлагатай.				
ТӨӨЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 1 жил /2019/-ийн борлуулалтын орлогын дундаж нь 44 000 000 / дөчин дөрвөн сая/ төгрөгөөс багагүй байна				
ТӨӨЗ 18.3	Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд: Түншлэлийн гишүүд нь ТӨӨЗ-ны 5.2-ийн “а-и” заасан мэдээллийг нотлох баримтын хамт заавал ирүүлнэ.				
ТӨӨЗ 18.3.1	Тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хувь хүртэл байна. Туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг эх хувиар ирүүлнэ. Санал болгож буй туслан гүйцэтгэгчийн чадварын мэдээллийг МАЯГТ №: ТШМ-5А - ийн дагуу ирүүлнэ. Гэрээнд туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажлын талаар болон төсөвт өртгийг тодорхой тусгасан байна. Үүнээс дээш хувийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх бол түншлэлийн гэрээ байгуулж тендерийн хамт ирүүлэх ба тендерийн бичиг баримтад дурьдсан бусад шалгуурыг хангасан байх ёстой.				
ТӨӨЗ 20.1	Тендер нээснээс хойш [30] хоногийн туршид хүчинтэй байна.				
ТӨӨЗ 21.1	Тендерийн баталгааны хэмжээ буюу мөнгөн дүн нь: “ Шаардахгүй ”				
ТӨӨЗ 21.4	Тендерийн баталгааг 4 дүгээр бүлэг дэх маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагч урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ				

Г. Тендер ирүүлэх	
ТӨӨЗ 23.3 (б)	:Захиалагч нь: Баянзүрх дүүрэг 11-р хороо Хонхор хотхон Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага
ТӨӨЗ 23.3	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Баянзүрх дүүрэг 11-р хороо Хонхор хотхон ШШГЕГ –ын Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага ШШГЕГСХТ/20200102/
ТӨӨЗ 23.3 (в)	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: ШШГЕГ-ын харъяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага БЗД-11-р хороо, Хонхор хотхон Давхар болон өрөөний дугаар: Санхүүгийн албаны өрөө Огноо: 2020 оны 10 дугаар сарын 29-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут
Д. Тендерийг нээх, үнэлэх	
ТӨӨЗ 28.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: ШШГЕГ-ын харъяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага БЗД-11-р хороо, Хонхор хотхон Давхар болон өрөөний дугаар: Хурлын заал. Огноо: 2020 оны 10 дугаар сарын 29-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут
ТӨӨЗ 42.1	Гүйцэтгэлийн баталгаа: “Шаардахгүй”

ГУРАВ: ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

Чанарын Үзүүлэлтүүд	Чийглэг % ихгүй	Нийт хүхрийн %-аас ихгүй	Дэгдэмхий бодис %, ихгүй	Үнслэг %, ихгүй	Илчлэг ккал/кг, багагүй
Нүүрс	15.9	1.2	27	23	4000-5500 хүртэл

❖ Нүүрс тээврийн ажлын техникийн тодорхойлолт нь техникийн бүрэн бүтэн байдлаар бүрэн илэрхийлэгдэнэ. Нүүрс тээврийн ажлыг гүйцэтгэхдээ техникийн баримт бичгийн үндсэн бүрдэл хэсэг болох Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ачаа тээврийн норм ба дүрэм, стандарт, техникийн нөхцлийг нэг бүрчлэн баримталж ажиллана.

❖ Нүүрс тээвэрлэлтийн ажил гүйцэтгэгч нь нийт 3-аас доошгүй хөдлөх бүрэлдэхүүнтэй байна.

❖ Нүүрс тээвэрлэлтийн ажил гүйцэтгэгч нь нийт хөдлөх бүрэлдэхүүний 50 хувиас багагүй нь өөрөө буулгагч байх.

❖ Өөрөө буулгах боломжгүй тээврийн хэрэгслийн тэвш болон чиргүүл нь ачааг ковшоор түрж буулгаж болдог зориулалтай байх.

❖ Түрж буулгах боломжгүй тэвш болон чиргүүлд ачсан ачааг буулгахад гарах зардлыг ачаа хүлээн авагч тал хариуцахгүй.

❖ Нүүрс тээвэрлэлтийн ажил гүйцэтгэх шугаман болон сүлжээ график, санхүүжилтийн хуваарь ирүүлэх.

❖ Нүүрс тээвэрлэлтийн хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн ажиллагааг хангах. Хөдөлмөр хамгаалалт аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн норм дүрэм, стандарт, ажлын байран дахь үзүүлэн таниулах материал, тэмдэг тэмдэглэгээ зайлшгүй байх шаардлагатай.

❖ Нүүрс тээврийн ажлыг ачаа тээврийн норм дүрэм, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

❖ Нүүрс тээвэрлэлтийн ажил гүйцэтгэгч нь чанар стандартыг хангасан нүүрс ачиж явуулахыг нийлүүлэгч талд тавьж, ашиглалтын шаардлага нийцсэн, элдэв механик хольцгүй нүүрс тээвэрлэх шаардлагатай. Хүлээн авагч тал тээвэрлэж ирсэн нүүрсний дээжийг шинжилж үзээд шаардлагад нийцэхгүй бол хүлээж авахгүй бөгөөд нүүрс буцаахад гарах зардалыг хариуцахгүй.

❖ Тендерт шалгарсан тохиолдолд гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, ажил эхлэх, дуусах хугацаа, тээвэр хийх жолооч нарын болон тээврийн хэрэгслийн мэдээлэл зэргийг уг ажил эхлэхээс өмнө захиалагч талд гаргаж өгнө.

НҮҮРС ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЕ ШАТНЫ БОЛОН САНХҮҮЖИЛТЫН ХУВААРЬ

Нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Санхүүжилт	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
Нүүрс	тн	830 тонн	54 000 000	УБ хот, БЗД 11-р хороо, Хонхор хотхон	2020.10.15	2021.01.20	

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тоо хэмжээ	10-р сар	11-р сар	12-р сар	Дүн /тн/
Нүүрс	тн	300	300	230	830
Мөнгөн дүн		19.518.000	19.518.000	14.964.000	54.000.000

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

1. **ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(**Захиалагч байгууллагын нэр**)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [**санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр**] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [**тоо**] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 10хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- а. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас томилогдсон комисс мэргэжлийн хяналтын байгууллагын шинжилгээний дүгнэлтийг үндэслэн шалгаж хүлээн авна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- а. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- а. Баталгаат засварын тусгай шаардлага. Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг хэрэглэх явцад гарсан гологдлыг тухай бүр шинэчлэн сольж өгнө.
- а. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуухийнэ.
1. **Урьдчилгаа төлбөр:** Байхгүй
 2. **Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:** Байхгүй.
 3. **Барааг хүлээн авахад төлөх төлбөр: 100 хувь /**
Барааны төлбөрийг гүйцэтгэлээр нь буюу бараа хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийг хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- а. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн 7 хоног тутамд 0,5%
- Алдангийн нийт дүн: 10% иас хэтрэхгүй байна.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ:

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/ гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;

Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]
